

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/001/НА-СТА-ТӨҮГ

Цахимхуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот

2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа

Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Аудитор: А.Лхагвагэрэл

Утас: 70350757 Цахим хаяг: lkhagvagerel.a@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.13 № 89
танай _____-ны № _____-г

“ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ
М.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Эрчим хүчний төсөл 2"-ын хүрээнд авсан 16.1 сая ам долларын урт хугацаат зээлийн 2025 онд төлөх үндсэн зээлийн төлбөр 4,605.7 сая төгрөгийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн байна. Зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг төлөх үед гарсан валютын ханшийн зөрүүгээс 1,932.1 сая төгрөгийн алдагдал үүссэн байна.

Телевиз, даатгал, хог хаягдлын хураамжуудыг цахилгааны төлбөртэй хамт нэхэмжилж, өөрийн үйл ажиллагааны дансанд төвлөрүүлснээс шалтгаалан 197.9 сая төгрөгийн өр төлбөр үүсгэжээ.

Аудитын гол асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгаан түгээлтийн алдагдлыг 13.68 хувиар баталж, 13.22 хувь хүртэл 0.47 нэгжээр бууруулсан байна.

612507786

Бусад асуудлын хэсэг

Сангийн яам, Эрчим хүчний яаманд дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийг хуваарийг шийдвэрлүүлэх саналыг 2024 онд хүргүүлсэн боловч, одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П. ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	659,248,869.96	44,407,058.07
1.1.2	Дансны авлага	20,923,918,491.66	14,711,365,298.40
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	223,958,744.58	312,145,719.46
1.1.4	Бусад авлага	43,949,782.79	45,085,305.43
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	9,715,468,238.67	9,429,875,941.66
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	549,952,224.11	172,878,185.98
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	32,116,496,351.77	24,715,757,509.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	129,784,823,796.51	158,950,764,376.08
1.2.2	Биет бус хөрөнгө	5,027,453,849.52	4,727,352,406.72
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,437,826,303.39	1,735,904,429.20
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	162,562,969,510.55	165,414,021,212.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	194,679,465,862.32	190,129,778,721.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	14,756,779,022.00	12,799,151,803.84
2.1.1.2	Цалингийн өглөг	-	92,080,897.07
2.1.1.3	Татварын өр	83,064,754.31	384,691,320.79
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	280,937,226.60
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	430,247,338.93	421,559,172.82
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	832,834,379.51	766,943,084.49
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)	8,348,241,752.40	9,214,570,229.60
2.1.1.10	Богино хугацаат өр төлбөр	-	281,002,525.99
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	24,451,167,247.15	24,240,936,261.20
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	41,187,114,537.35	41,026,736,049.60
2.1.2.2	Нөөц (өр төлбөр)	77,802,038.15	127,666,615.75
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	4,868,106,441.99	4,642,459,815.62
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	8,183,267,079.47	8,651,244,844.44
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	54,316,290,096.96	54,448,107,325.41
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	78,767,457,344.11	78,689,043,586.61
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	48,120,648,100.00	48,120,648,100.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-

2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	81,831,522,105.67	82,938,409,778.16
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	3,067,422,460.00	3,067,422,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(17,107,584,147.46)	(22,685,745,203.77)
2.3.11	Эздийн өмчийн дүн	115,912,008,518.21	111,440,735,134.39
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	194,679,465,862.32	190,129,778,721.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	443,643,398,236.45	526,936,372,094.10
2	Борлуулалтын өртөг	418,044,781,620.57	500,688,345,281.61
3	Нийт ашиг /алдагдал/	25,598,616,615.88	26,248,026,812.49
4	Түрээсийн орлого	55,195,200.00	70,268,800.00
5	Хүүний орлого	74,709,715.07	113,698,519.18
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	4,060,020,820.05	1,412,066,324.21
9	Борлуулалт, маркетингийн зардал	10,825,543,589.43	13,011,688,196.68
10	Ерөнхий ба удирдлагын зардал	14,798,573,400.80	16,864,679,750.25
11	Санхүүгийн зардал	923,792,975.80	1,521,820,646.35
12	Бусад зардал	462,259,660.19	597,878,370.87
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(177,084,043.20)	(1,932,137,849.75)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	29,587,281.82	14,113,657.72
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,630,875,963.40	(6,070,030,700.30)
19	Орлогын татварын зардал	234,984,538.11	11,369,851.93
19.1	Хойшлогдсон татварын зардал	(235,541,446.98)	(500,574,006.71)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,631,432,872.27	(5,580,826,545.52)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,631,432,872.27	(5,580,826,545.52)
23	Бусад дэлгэрэнгүй орлого, зарлага	63,559,281.24	1,110,222,882.49
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	63,559,281.24	1,110,222,882.49
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	2,694,992,153.51	(4,470,603,663.03)
1	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01 сарын 01 үлдэгдэл	48,120,648,100.00	82,101,273,359.85	3,033,798,460.00	(19,944,078,766.57)	113,311,641,153.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	48,120,648,100.00	82,101,273,359.85	3,033,798,460.00	(19,944,078,766.57)	113,311,641,153.28
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,631,432,872.27	2,631,432,872.27
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	63,559,281.24	-	-	63,559,281.24
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	33,624,000.00	-	33,624,000.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(333,310,535.42)	-	205,061,746.84	(128,248,788.58)
9	2024 оны 12 сарын 31 үлдэгдэл	48,120,648,100.00	81,831,522,105.67	3,067,422,460.00	(17,107,584,147.46)	115,912,008,518.21
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	48,120,648,100.00	81,831,522,105.67	3,067,422,460.00	(17,107,584,147.46)	115,912,008,518.21
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(5,580,826,545.52)	(5,580,826,545.52)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	1,110,222,882.49	-	-	1,110,222,882.49
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(3,335,210.00)	-	2,665,489.21	(669,720.79)
17	2025 оны 06 сарын 30 үлдэгдэл	48,120,648,100.00	82,938,409,778.16	3,067,422,460.00	(22,685,745,203.78)	111,440,735,134.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлтүүд	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	554,009,261,569.84	683,494,051,776.04
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	431,199,157,123.68	534,554,105,784.04
	Салбараас орлого төвлөрүүлэлт	47,276,198,463.60	64,628,421,152.18
	Татаас, санхүүжилтийн орлого	69,806,486,082.29	79,434,581,238.90
	Бусад мөнгөн орлого	5,727,419,900.27	4,876,943,600.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	550,985,639,006.61	677,373,800,186.51
	Ажиллагчдад төлсөн	20,544,518,760.49	23,760,929,980.93
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,032,980,323.83	6,899,257,857.74
	Бараа материал худалдан авахад төлсөн	437,053,168,517.25	541,343,765,377.83
	Ашиглалтын зардалд төлсөн	132,646,654.08	135,295,307.70
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,062,358,471.40	1,911,304,795.20
	Хүүний төлбөрт төлсөн	1,400,092,377.37	1,552,866,122.56
	Татварын байгууллагад төлсөн	6,615,542,287.43	6,278,762,687.76
	Даатгалын төлбөрт төлсөн	23,769,340.88	22,586,510.00
	Бусад мөнгөн зарлага	6,752,813,810.28	6,811,510,394.61
	Салбарт санхүүжилт	22,091,550,000.00	24,029,100,000.00
	Төвлөрүүлэлт	47,276,198,463.60	64,628,421,152.18
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,023,622,563.23	6,120,251,589.53
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	74,709,715.07	128,578,542.18
	Хүлээн авсан хүүний орлого	74,709,715.07	113,698,519.18
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,666,303,469.80	2,926,909,612.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,666,303,469.80	2,735,882,324.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	191,027,288.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,591,593,754.73)	(2,798,331,069.82)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,728,899,297.62	3,936,762,331.60
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	2,728,899,297.62	3,936,762,331.60
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,728,899,297.62)	(3,936,762,331.60)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,296,870,489.12)	(614,841,811.89)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,956,119,359.08	659,248,869.96
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	659,248,869.96	44,407,058.07
	Нийт зөрүү	(1,296,870,489.12)	(614,841,811.89)

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт		хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		төлөвлөгөөнөөс	
					төлөвлөгөө	гүйцэтгэл	биет	хувь
1	Худалдаж авсан цахилгаан		сая.кВтц	1,507.5	1,567.3	1,559.0	-8.3	-0.5%
	ЦЭХ-ний алдагдал	нийт дүнгээр	%	3.58%	3.59%	3.35%	-0.24%	
		биетээр	сая.кВтц	53.9	56.3	52.2	-4.0	-7.2%
	Борлуулах цахилгаан эрчим хүч		сая.кВтц	1,453.6	1,511.1	1,506.8	-4.3	-0.3%
2	Нийт орлого		сая.төг	447,862.9	522,419.3	528,546.5	6,127.2	1.2%
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	400,447.3	475,151.1	480,219.1	5,068.0	1.1%
		Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	42,300.6	45,590.2	45,590.2	0.0	0.0%
		Татаасын орлого	сая.төг	2,939.4	0.0	0.0	0.0	
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	2,175.7	1,678.0	2,737.2	1,059.2	63.1%
3	Нийт зардал		сая.төг	445,232.0	530,197.4	534,616.6	4,419.1	0.8%
	Үндсэн үйл ажиллагааны зардал		сая.төг	444,029.2	529,195.2	531,392.7	2,197.5	0.4%
	Үүнээс:	Элэгдэл	сая.төг	10,392.4	11,951.0	11,692.5	-258.5	-2.2%
		Бусад тогтмол	сая.төг	39,262.2	47,552.5	45,875.2	-1,677.3	-3.5%
		Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	394,374.6	469,691.8	473,825.0	4,133.3	0.9%
	Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	1,202.9	1,002.2	3,223.8	2,221.7	221.7%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	2,630.9	-7,778.1	-6,070.0	1,708.1	-22.0%
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	2,631.4	-7,778.1	-5,580.8	2,197.3	-28.2%
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төгрөг	0.99	1.01	1.01	0.00	-0.3%
7	Нийт авлага		сая.төг	21,191.8	19,174.0	15,068.6	-4,105.4	-21.4%
	Үүнээс:	ЦЭХ-ний	сая.төг	20,923.9	19,054.0	14,711.4	-4,342.6	-22.8%
		Бусад	сая.төг	267.9	120.0	357.2	237.2	197.7%
8	Нийт өглөг		сая.төг	78,767.5	85,244.9	78,689.0	-6,555.9	-7.7%
	Үүнээс:	Богино хугацаат	сая.төг	24,451.2	25,218.7	24,240.9	-977.8	-3.9%
		Урт хугацаат	сая.төг	54,316.3	60,026.2	54,448.1	-5,578.1	-9.3%
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	655	664	661	-3.0	-0.5%
10	Нийт цалингийн сан		сая.төг	24,348.5	28,775.2	27,864.1	-911.1	-3.2%
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа		минут	749.3	1,048.0	673.3	-374.7	-35.8%
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	6,250.4	8,923.8	8,242.3	-681.5	-7.6%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдааны¹ залруулга хийгээгүй.

Аудитаар нийт 525.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.3 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 497.2 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 22.7 сая төгрөгийн 12 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

"ЭБЦТС" ТӨХК-ийн Хархорин салбарын ажилтанд 0.5 сая төгрөгийг цалин илүү олгосон, гүйцэтгэх захирлын зөвшөөрөл, нотлох баримтгүйгээр 0.5 сая төгрөгийн томилолтын зардал олгосон, 4.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн зөрчлүүдэд 3 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээг 5 компанитай байгуулж, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй зардалд хөрөнгө зарцуулсан, хог хаягдал, телевиз, даатгалын хураамжийн 281.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүсгэсэн, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажиллагсдын хоолны хөнгөлөлт, түлшний хөнгөлөлт, ахмадын сангийн зардал, шагнал урамшууллын зардлыг 70.8 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан, ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 27.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон, төв компанийн корпусын дотор агааржуулалт, салхивчны засварыг зураг төсөвгүй, барилгын засварын үйл ажиллагаа эрхэлдэггүй компаниар гүйцэтгүүлж, санхүүжилтэд 18.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчлүүдэд 5 албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

"Эрчим хүчний төсөл 2"-ын хүрээнд авсан зээлийн 2025 онд төлөх үндсэн зээлийн төлбөр 4,605.7 сая төгрөгийг графикайн дагуу төлөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөр үүсгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн яам, Эрчим хүчний яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний 3.1.3-т "Үндсэн болон хүүгийн төлбөр төлөх огноо: жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15-нд төлөх", 3.3-т "Дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлөх ба аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 1: "Эрчим хүчний төсөл 2"-ын хүрээнд авсан урт хугацаат зээлийг хуваарийн дагуу төлөх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2:

Тайлант онд 2.1 сая төгрөгийн байгууллагаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-т "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талуудын тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 2:

Компанийн тайланд тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан авлагыг бүртгэж байх.

3. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 3:

Тайлант онд 9.6 сая төгрөгийн өр төлбөрийг аж ахуйн нэгжтэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-т "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талуудын тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 3:

Компанийн тайланд тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан өр төлбөр бүртгэж байх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 4:

Газар эзэмших эрхийн 24 нэгж талбарыг үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын

3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 4:

Газар эзэмших эрхийн 24 нэгж талбарыг 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд бүртгэх.

5. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 5:

Тооллогоор бүртгэлд тусгагдаагүй 18 нэр төрлийн 180 ширхэг хөрөнгө тоолсныг бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах Байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж, данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 5:

Тооллогоор бүртгэлд тусгаагүй 18 нэр төрлийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулж бүртгэх.

6. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 6:

Байгууллага 8 суудлын автомашин ашигладаг боловч автомашин хүрэлцээгүй шалтгаанаар албан хаагчдад 10.9 сая төгрөгийн шатахууны талоныг хэрэгцээ шаардлагыг тодорхойлохгүйгээр олгож, тооцоо бодож хянаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 6:

Байгууллагын ажил үүргийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүнд нийцүүлэн шатахууны зардал олгож, тооцоог хянаж байх.

7. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 7:

Шатахуун зарцуулалтын нормыг Зам тээвэр хөгжлийн сайдын баталсан жишиг нормоос өндрөөр тогтоож, төсвийг хэмнэлттэй зарцуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрмийн 8.10.2 "Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг мэдээлэх", 8.10.4 "Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 7:

Байгууллагын шатахуун зарцуулалтын нормыг шинэчлэн мөрдөж ажиллах.

8. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 8:

Бараа хүлээн авсан акт үйлдсэнээс хойш гэрээ дүгнэсэн актыг журамд заасан хугацаанаас хэтрүүлэн дүгнэсэн байна.

Энэ нь Компанийн худалдан авах ажиллагааны журмын "5.3.4-т "Гүйцэтгэгчийн бараа, ажил, үйлчилгээ болон дагалдах баримтын бүрдэл бүрдсэн огноогоор хүлээлцсэнд тооцож ажлын 3 хоногийн дотор комиссын актыг үйлдэнэ", 5.4.1-т "Бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах комиссын шийдвэр болон энэ журмын М1070/Ж-01-11, М1070/Ж-01-12 заасан маягтыг хүлээлгэн өгснөөс хойш ажлын 2 хоногийн дотор энэ журмын М1070/Ж-01-14 маягтын дагуу гэрээ дүгнэсэн актын төслийг 3 хувь үйлдэж, захиалагч талын холбогдох албан тушаалтнууд болон нийлүүлэгч, гүйцэтгэгч талууд баталгаажуулсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 8:

Компанийн худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж, салбар, хэлтсийн үйл ажиллагааны хоорондын уялдааг сайжруулах.

9. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 9:

Салбарын албан хаагчдад олгож буй тэтгэмж, буцалтгүй тусламжийн холбогдох анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангасан эсэхэд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх

удирдлага хүлээнэ”, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрмийн 8.10.2 "Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг мэдээлэх", 8.10.4 "Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 9:

Компанийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнууд салбар, нэгжийн санхүүгийн баримтын иж бүрдлийг хангуулж, хяналт хэрэгжүүлэх.

10. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 10:

Албан томилолтын удирдамжид хийх ажлын даалгавар, төлөвлөгөөг бүрэн тусгаагүй, ажлын гүйцэтгэлийн тайланг дэлгэрэнгүй хөтлөөгүй, албан томилолтын журамд заасан хугацаанд холбогдох баримтыг бүрдүүлдэггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Гүйцэтгэх захирлын 2025 оны А/11 дүгээр тушаалаар баталсан "Албан томилолтоор ажиллах журам"-ын 4.1.3-т "Албан томилолтоор ажилласан гүйцэтгэлийн тайланг хянаж, ажилласан хоногийн тоог баталгаажуулна", 4.3.7-д "Томилолтоор ажилласан гүйцэтгэлийн тайланг ажлын 3 хоногт багтаан ажилтан нэгжийн удирдлагад гаргаж танилцуулна", 4.3.8-д "Нэгжийн удирдлага гүйцэтгэлийн тайланг хянаж, томилолтын үр дүнг тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 10:

Албан томилолтын зардлыг баталсан журмын дагуу олгож, баримтын бүрдлийг хангуулж ажиллах.

11. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 11:

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар 1-ээс дээш оролцогчтой 36 худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас давхардсан тоогоор 15 оролцогч Сангийн яаманд гомдол гаргаж, нийт гаргасан гомдлын 30.5 хувь буюу 11 гомдлыг захиалагч үндэслэлгүй шийдвэр гаргасан гэж үзсэн байна. Үнэлгээний хороо нь тендерийг холбогдох хууль, журамд нийцүүлж үнэлээгүйгээс тендерт оролцогчид гомдол гаргасан нь тендер үр дүнгүй болох, компанийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх эрсдэлийг үүсгэхээр байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4.3-т "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.9-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ",

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дүрмийн 8.10.4-т "Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 11:

Сангийн яамны дүгнэлтийг харгалзан компанийн худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүд, үнэлгээний хорооны гишүүдийн гүйцэтгэлийг үнэлж байх.

12. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 12:

Ижил төстэй бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа шууд худалдан авалт хийх зорилгоор төсөвт өртгийг хуваан худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 12:

Шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваахгүй байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭБЦТС ТӨХК												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
ЭБЦТС ТӨХК	18	525.2	3	5.3	5	497.2	10	22.7				
Дүн	18	525.2	3	5.3	5	497.2	10	22.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЭБЦТС ТӨХК								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЭБЦТС ТӨХК	2	-					2	-
Дүн								
Нийт дүн	2	-					2	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хягаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			